

Д/д	Оролцогчийн тодруулга	Захиалагчийн хариулт
1	I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа 13. Тендерийн иж бүрдэл 13.2.2: Асуулт: Тогтоосон итгэмжлэлийн маягт байвал өгөх, агуулгыг тодорхой болгох	Тодорхойлсон итгэмжлэлийн маягт тендерийн баримт бичигт тусгаагүй тул үүсгэн байгуулагдсан улсын хууль, тогтоомжийн дагуу бэлтгэнэ.
2	I Бүлэг. ТШЗ. 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт 21.4. Асуулт: Төслийн менежментийн зөвлөхийн гэрээг байгуулсны дараа үнийн тохируулга хийхгүй гэх агуулгыг тодорхой болгох хэрэгтэй (Жич): Инфляцийн өсөлтийг тусгах мөн нэмэлт ажил дээр гэрээний өөрчлөлт хийх, Захиалагчаас шалтгаалсан ажлын график хойшлох, ТЭЗҮ (FS), эскиз зураг боловсруулж дуусгаад төслийн нийт зардлыг тооцон гаргасны дараа ч төслийн менежментийн зөвлөхийн ажлын үнийг нэмэхгүй гэсэн утгатай юу?	Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ. ТШЗ 21.4 Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулна” Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно
3	I Бүлэг. ТШЗ. 22. Тендерийн валют 22.1. Асуулт: Монгол төгрөгөөр гэрээний үнийг бичих тохиолдолд ам.долларын ханшийн зөрүүгийн эрсдэлээс хэрхэн сэргийлэх вэ? Олон улсын сонгон шалгаруулалт хэр нь валютыг Монгол төгрөгөөр хийх нь тохиромжгүй байна.	Тендерийн үнийн саналыг гадаад орны валютаар ирүүлж болох тендерийн шалгаруулалтын үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27.2.2 дахь заалт, 28.7 дахь хэсгийн дагуу гадаад валютуудад ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк (Монгол банк)-ны албан ханшаар тооцож хөрвүүлнэ. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2 дахь заалтуудын төгрөгөөр хийнэ. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
4	I Бүлэг. ТШЗ. 37. Урьдчилгаа төлбөр 37.1: Асуулт: Гэрээг байгуулсны дараа ч урьдчилгаа олгохгүй гэсэн утга уу? Үүнийг тодруулах, Урьдчилгаа олгох бол аль үе шатанд хэд орчмыг олгох талаар тодруулах мөн гүйцэтгэлийн төлбөр олгох нөхцөлийг тодорхой болгох	ТШЗ. 37.1 дагуу Урьдчилгаа төлбөр олгохгүй. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
5	II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт 18.1.2 Асуулт: Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ гэдэг агуулгыг тодорхой болгох	Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гүйцэтгэгчээс гаргах боломжтой мөнгөн хөрөнгө.
6	II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт 18.1.3 Асуулт: Зээлтэй холбоотой агуулгыг тодорхой болгох	Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна. Хэрэв гадаадын хуулийн этгээд бол Банк санхүүгийн байгууллагаас хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй гэсэн тодорхойлолт ирүүлнэ. Зээлийн ангилал нь “Хэвийн” байх шаардлагатай.

7	II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт 19.1.3: Асуулт: Оролцогч этгээд гэдэг нь 1. Төслийн багийн захирал ~ 12. Санхүү хяналтын менежер хүртэл үүнд хамаарах уу? Дээрх 1 - 12 хүртэл бүх хүнд энэ шаардлага тавигдах уу эсвэл боловсон хүчин тус бүрт шаардах нөхцөлүүд нь өөр өөр байх уу? Тодорхой болгох	Өгөгдлийн хүснэгт 19.1.3 дахь заалт нь зөвхөн тендерт оролцож буй аж ахуйн нэгжийн хувьд шаардаж байгаа болно.
8	II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт 21.4 : Асуулт: 1-р бүлгийн ТШЗ: 21.4-т тохируулга хийхгүй гэж заасан байгаа бол, 2-р бүлгийн 21.4-т “Тохируулна” гэж заасан нь зөрчилдөж байна. “Тохируулна” гэвэл ямар тохиолдолд, ямар хэм хэмжээтэй тохируулах боломжтой болохыг тодорхой болгох хэрэгтэй.	Үнийг тохируулна. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
9	ТШЗ 7.3-д заасны дагуу - Оролцогч, туслан гүйцэтгэгчээр оролцохыг оролцогч, туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан. ТШХ-ийн 7.4-т зааснаар “Гадаадын этгээдийг эсрэг этгээдээр оруулахад ХӨХ-ийн 7.3-т заасан заалт хамаарахгүй” гэж заасан. Асуулт нь: Тендерт оролцогч өөрийн санхүүгийн чадавхийг толгой компанийн зардлаар баталгаажуулж чадах уу (толгой компанид баталгаа гаргах)?	17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. Түншлэлийн гэрээ болон туслан гүйцэтгэгчийн гэрээг гадаадын этгээд бол цахим системээр баталгаажуулж ирүүлэх шаардлагагүй материалдаа ирүүлэхэд болно.
10	Тэмцээний 2-р шатанд гадаадын хэд хэдэн байгууллага хамтран оролцохоо зарлах боломжтой юу?	Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.
11	Гадаадын банкнаас банкны баталгаа гаргасныг яаж баталгаажуулах вэ?	Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралт “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 4 дэх хэсгийн дагуу гаргаж ирүүлнэ.
12	ТШЗ 18.2-д зааснаар борлуулалтын орлогын талаарх мэдээллийг санхүүгийн тайлангийн үндсэн дээр баталгаажуулах ёстой тул сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан шаардлагатай. Санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг нотлох баримт болгон төрийн байгууллагуудаас (Татварын алба) баталгаажуулж болох уу?	Болохгүй. Борлуулалтын орлогын мэдээллийг тендерт оролцогчийн санхүүгийн тайлангаас шалгах тул сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлэх шаардлагатай.
13	37.1-д зааснаар гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг урьдчилгаа төлбөрт хийгээгүй. Гэрээнд урьдчилгаа төлбөр	Тендерийн баримт бичгийн ТШЗ. 37.1 дагуу Урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан.

	байгаа юу? Мөн энэ урьдчилгаа төлбөрт банкны баталгаа гаргах шаардлагатай юу?	Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
14	Тендерийн бичиг баримт болон техникийн шаардлага аль алинд нь төслийн тендерийн баталгааны бичгийн төсөл/драфтыг оруулаагүй байсан, тендерийн баталгааны бичиг гаргахад жишиг болгож ашиглах үүднээс драфтыг ирүүлж болох уу. Тендерийн баталгааны хүчинтэй хугацааг мөн тодорхой болгоно уу.	Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын Маягт 1-ийн дагуу гаргаж ирүүлнэ.
15	Гадаадын хуулийн төлөөлөгч охин компанийнхаа ажлын туршлага (бүртгүүлсэн улс дахь) ашиглаж байгаа бол охин компанийг тендер, худалдан авах ажиллагааны системд бүртгүүлэх, тендерийн системд түншлэлийн гишүүнээр баталгаажуулахыг шаардах уу. Тендерт оролцогчийн охин компанийн ажлын туршлага ашиглахын тулд охин компаниудтай түншлэл байгуулж, тендерийн системээр баталгаажуулах шаардлагатай эсэх.	Гадаадын хуулийн этгээд охин компаний чадавхийг тендер шалгаруулалтад ашиглахгүй (Хэрэв эхний шатанд оролцох мэдээлэл ирүүлээгүй бол). Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.
16	31.1-д заасан "Өгөгдлийн хуудсанд заасан бол 4 дүгээр бүлэгт заасан үнэлгээний стандартад нийцсэн стандартыг мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, харьцуулсан үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ." гэдгийг хэрхэн ойлгох вэ.	Энэ шалгуурыг мөрдөхгүй.
17	Маягт 3-т заасан "гэрээнд оролцох статус (дараах хувилбаруудаас аль нэгийг нь сонгоно бий) <input type="checkbox"/> үндсэн ханган нийлүүлэгч <input type="checkbox"/> түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> туслан гүйцэтгэгч" гэдэг нь үндсэн гүйцэтгэгч, түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч болох уу.	Тийм.
18	Маягт 9-ийн машин механизмын тоног төхөөрөмж гэдэг нь геологийн ерөмдлөгийн машин, хэмжилтийн тоног төхөөрөмж болон туршилт шинжилгээний тоног төхөөрөмж зэргийг зааж байгаа эсэх	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж байж болно.
19	Нэрсийн жагсаалтад багтаагүй компани хамтралын гишүүний хувиар тендерт оролцож болох эсэх	Үгүй
20	Хэрэв хамтарсан байдлаар тендерт оролцвол тендерийн баталгааг заавал хамтралын тэргүүн нь гаргах шаардлагатай эсэх? Хамтралын гишүүн гаргаж болох эсэх?	Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээдээр тендерийн баталгааг гаргуулна. Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 24.4-д Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

21	Энэ тендерийн шалгуур үзүүлэлт, Монгол улсад анх удаа хэрэгжих шинэ төрлийн төсөл зэргийг үзвэл гадаад улсын компани энэ тендэрт шалгарах нь зайлшгүй гэдгийг харгалзан үзэж гэрээний хэлийг Англи хэл дээр хийх.	Гэрээний хэл Монгол, Англи хэл дээр байна. Хэрэв зөрүү үүсвэл Монгол хэл дээр хийгдсэн гэрээг баримтлана.
22	Гэрээний валютийг ОУ худалдааны байгууллагын үндсэн төлбөрийн хэрэгсэл болох Америк Доллараар хийх боломжтой эсэх.	Хуулийн заалт тавьж өгөх. Тендерийн үнийг вальютаар, гүйлгээг зөвхөн Монгол төгрөгөөр хийнэ.
23	Маргааныг шийдвэрлэх газраар талуудын эрх ашгийг тэгш хангахуйц ОУ ын Арбитрийн байгууллагыг сонгох.	Гэрээний тусгай нөхцөлд заасан заалтыг тавьж өгөх
24	Эхний шатанд оролцоогүй компанийг түншлэлийн ахлах гишүүнээр нэмж оролцуулах боломжтой юу (Эхний шатанд оролцсон компанийг түншлэлийн гишүүн байдлаар).	Болохгүй. Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.
25	ТШЗ 19.1ийн 3дах заалт дээр Заас доошгүй газар дээрх болон доор төсөл гүйцэтгэсэн гэдэг нь Газар доорх болон дээрх тус тус Зыг уу, нийлмэл ээр Зийг уу гэдгийг нарийвчлан тодорхойлж тайлбарлах.	“Газар дээрх болон доорх метроны бүтээн байгуулалтын ажилд” гэж тодорхой байдлаар буюу хамтад нь заасан болно.
26	ТШЗ 19.1ийн 3дах заалт дээр Заас доошгүй ижил төстэй төсөл дээр үндсэн зөвлөх хийсэн байна гэх заалтыг зөвлөх үйлчилгээний гэрээний дүнг ижил төстэй гэдэг утгаар ижил төсөвт 180 тэрбум төгрөг үнийн дүн бүхий гэрээгээр баталгаажуулах заалт оруулаагүй тохиолдолд, ОУн зарим төслүүд Зөвлөх үйлчилгээг мөн олон багцад хувааж зөвлөх хөлсөлдөг учир зөвхөн нэг өртөөний барилгын зургийг үндсэн зөвлөх гэрээгээр 3 удаа гүйцэтгэсэн компани ч энэ туршлагын шалгуурыг хангахаар байна. Ингэсэн тохиолдолд, Метроны цогц системийг удирдаж хянаж барьж байгуулсан туршлагагүй, зөвхөн хэсэгчилсэн туннел, өртөөний барилгын зураг зурсан л туршлагатай компани шалгарах эрсдэлтэй байна.	Оролцогч этгээд нь сүүлийн 10 жилийн хугацаанд 3-аас доошгүй удаа газар доорх болон газар дээрх барилга байгууламж бүхий их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл метроны төсөлд барилга угсралтын хяналт болон зураг төслийн хяналтын ажилд үндсэн гүйцэтгэгчээр менежментийн зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна. Ижил төстэй үйлчилгээнд тооцуулахаар ирүүлсэн 1 ажил нь хэрэгжилтийн шатандаа байж болно.
27	Гадаад этгээдийн холбогдох бичиг баримтыг Консулаар батлуулна гэсэн нь тухайн улсад суух Монгол улсын Консул уу? Тус улсаас Монгол улсад суух тухайн улсын Консул уу?	Апостил гэрчилгээг тухайн улс орны гадаад харилцааны яам буюу баримт бичгийг олгосон улсаас гаргадаг болно. (1961 Hague Convention уншина уу)

28	Техникийн тодорхойлолт дээр ТМЗийн гэрээний гүйцэтгэл, бэлтгэх бичиг баримтуудыг Монгол хэл дээр гэснийг Англи хэл дээр болгох.	Тус төсөл, арга хэмжээ нь орон нутгийн төсвөөс хэрэгжиж байгаа тул Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуулийг дагаж мөрдөх бөгөөд тус хуулийн дагуу батлагдсан Тендерийн жишиг баримт бичигт тендерийн баримт бичгийг монгол хэлээр бэлтгэхээр заасан.
29	Голлох 12 мэргэжилтэнгүүдийн шаардлагыг ирүүлсэн байгаа ч эдгээр ажилчдыг хамгийн багадаа хэдэн сар ажлуулах, нийт ажилчид хэдэн хүн.сар ажиллах шаардлага байхгүй байгаа нь тендерийг хянах, тэнцвэртэй үнээр шударга өрсөлдөх боломжгүй болгож байгааг мөн анхаарч, ОУн жишиг Тендерийн материалаас жишиг авч бэлтгэхийг хүсье. (Жишиг авч болохуйц: https://www.jica.go.jp/Resource/english/our_work/types_of_assistance/oda_loans/oda_op_info/guide/tender/c8h0vm0000aoesst-att/consul_202310.pdf)	Гэрээний хавсралтаар хүн/сар зэрэг мэдээллийг оролцогч өөрөө ирүүлэхээр заасан. Гэрээний хавсралт шалгана уу. Олон улсад гүйцэтгэгчээс санал авч гэрээний шатанд хэлэлцээр хийх туршлагад үндэслэсэн болно.
30	Уг тендерийг үнэлэх үнэлгээний аргачлалаа тайлбарлах.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтын дагуу “Харьцуулах үнэ” гэсэн үндсэн шалгуурыг баримтлана.
31	Дараагийн буюу EPC төслийн санхүүлжилт нь батлагдсан уу?	Батлагдсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан.
32	Тендерийн баримт бичиг англи хэл дээр ирээгүй хойшилсон хугацааг бодолцон мөн ерөнхийд нь тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах боломжтой юу? Тендер шалгаруулалтын өмнөх хурал дээр илэрхийлсэнчлэн тодруулга хэсэгт тендерийг хүлээж авах эцсийн хугацааг 14-өөс дээш хоногоор сунгах хүсэлтийг гаргаж байна. Мөн бусад оролцогчдыг хүсэлтээ илэрхийлэхийг уриалж байна.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 14 цаг 00 минут, Тендерийн нээлт хийх хугацаа нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 14 цаг 10 минут гэж өөрчлөв.
33	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга) англи хэл дээрх хувилбарыг хэрхэн хаанаас авч болох вэ?	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760359992351 (Эрх зүйн актын орчуулга)
34	Урьдчилгаа төлбөрийг гэрээнд тусгаж болох уу? ТШЗ 2.1.-д заагдсан 2024 оны санхүүлжилт нь ямар гүйцэтгэгдсэн ажлууд ба үйлчилгээнүүдийг санхүүжүүлэх зориулалттай вэ ?	Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
35	"Шаардлагатай" гэсэн тэмдэглэгээтэй заалтуудын аль нэгийг биелүүлээгүй нь тендерээс татгалзах хангалттай үндэслэл болох уу?	Тийм

36	Хавсаргах бичиг баримтын хэмжээ их ба тэдгээрийг апостилээр баталгаажуулахад их хугацаа шаардлагатай тул тендерийн нээх хугацааг 1 сараар сунгаж өгнө үү.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 14 цаг 00 минут, Тендерийн нээлт хийх хугацаа нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 14 цаг 10 минут гэж өөрчлөв.
37	Гадаадын компаниудын түншлэлийн гэрээг системээр дамжуулж "Түншлэл, Туслан бэлтгэх" цэсээр орж тоон гарын үсгээр харилцан баталгаажуулах шаардлагагүй. Зөвхөн гэрээний хуулбараа бусад бичиг баримтын хамт "Тендер бэлтгэх" хэсэгт оруулна гэж ярьсан.	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 7.4-т зааснаар ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
38	Тендерийг зөвхөн Түншлэлийн төлөөлөх эрх бүхий этгээд тоон гарын үсгээр дамжуулж илгээхэд хангалттай.	Тийм
39	Гадаадын хуулийн этгээд тендерийн баталгааг өөрийн улсын банкаар дамжуулж гүйцэтгэнэ. Харин тендерийн баталгааг илгээхдээ Монголын орон нутгийн арилжааны банкаар дамжуулж хийнэ. Орон нутгийн Банк болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем хоорондын холболт хийгдэж байгаа. Хэрэв хугацаанаас өмнө систем ашиглалтанд орохгүй бол Тендерт оролцогч нь тендерийн баталгааг биеэр авчирч Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт өгсөнөөр "Бид" систем рүү оруулж өгнө.	Энэ асуудалтай холбоотойгоор Төрийн худалдан авах ажиллагааны газар дэмжлэг үзүүлж ажиллана.
40	Тендерийн 1-р шатанд оролцоогүй хуулийн этгээд Түншлэлийн гишүүнээр оролцож болох тухай удахгүй үнэлгээний хорооны шийдвэр гарна.	Болохгүй. Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.
41	Тендерийг үнэлэх онооны систем байхгүй. Үнийн саналуудыг хооронд нь харьцуулах замаар сонгон шалгаруулна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтын дагуу "Харьцуулах үнэ" гэсэн үндсэн шалгуурыг баримтлана. Тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан

		аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.
42	Ижил төстэй ажил ШТЗ 19.2 заасны дагуу "Ижил төстэй ажил үйлчилгээнд Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл метроны төсөлд барилга угсралтын хяналт болон зураг төслийн хяналтын ажилд менежментийн зөвлөх үйлчилгээг тооцно" гэснийг хатуу баримтлана.	Тийм
43	Гэрээний үнийн саналыг ам.доллараар өгч болно. Гэрээ ам.доллараар байгуулагдах эсэхийг гэрээний хэлэлцээрийн шатанд шийднэ.	Болно. Тендерийн үнийн саналыг гадаад орны валютаар ирүүлж болох тендерийн шалгаруулалтын үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27.2.2 дахь заалт, 28.7 дахь хэсгийн дагуу гадаад валютаар ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк (Монгол банк)-ны албан ханшаар тооцож хөрвүүлнэ. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2 дахь заалтуудын төгрөгөөр хийнэ. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
44	Урьдчилгаа төлбөрийн талаар гэрээний хэлэлцээрийн явцад шийдвэрлэнэ.	Тийм
45	Бид үүгээр Тендер хураалгах эцсийн хугацааг 30 хоногоор сунгахаар хүсэлт гаргаж байна	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 14 цаг 00 минут, Тендерийн нээлт хийх хугацаа нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системийн цагаар 14 цаг 10 минут гэж өөрчлөв.
46	Тендерийн баримт бичигт бүрдүүлэх бүх баримт бичгийг гадаадын этгээд тухайн улсын консулын баталгаа эсвэл аппостил хийлгэх шаардлагыг заасан байна. Зарим бичиг баримтуудыг Консулын баталгаа эсвэл апостилгүй бэлдэх боломжтой юу? Учир нь тухайн бичиг баримтуудыг бид өөрсдөө бэлтгэж байгаа учир. Ж.нь: ижил төстэй төслүүдийн мэдээлэл, ажилтны намтар, ирээдүйд хэрэгжүүлэх төслүүдийн мэдээлэл, техник хэрэгслийн жагсаалт гэх мэт.	Консулын баталгаа эсхүл апостиль шаардсан хэсэгт бүгдийг нь шаардана.

47	Тендерийн баримт бичигт дурьдсанаар түншлэлийн гишүүн бүр санхүүгийн болон техникийн чадавхын шаардлагын дагуу хамгийн багадаа 25%-ыг ханахаар заасан байна. Энэхүү шаардлагыг үндэсний аль нэг аж ахуйн нэгж хангаж чадах нь эргэлзээтэй. Энэ шаардлагыг үндэсний компаньд хатуу тавих уу? Эсвэл туршлагыг өөр салбарын ижил цар хүрээний ажлаар адилтган тооцох уу?	Шалгуур үзүүлэлт бүх оролцогчдод ижил тэгш байдлаар хамаарна. "Ижил төстэй ажил үйлчилгээнд Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл метроны төсөлд барилга угсралтын хяналт болон зураг төслийн хяналтын ажилд менежментийн зөвлөх үйлчилгээг тооцно"
48	Зөвлөх үйлчилгээний үнэ тарифын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч болох уу? Хэрэв Зөвлөх үйлчилгээний ажил төсөвт өртөгөөс давсан тохиолдолд нэмэгдэл зардлыг хэн хариуцах вэ?	Үнэ 181.9 тэрбум байна. Оролцогч саналаа батлагдсан төсөвт багтаан ирүүлнэ.
49	Ажилтны намтарыг бэлтгэхэд хуудасны хязгаар зааж өгөх үү?	Үгүй
50	Бид Барилга угсралтын бус зөвлөх үйлчилгээний компань учир төсөлд ашиглах техник хэрэгслийн жагсаалтын талаар тодорхой ойлголтоггүй байна. Та энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч болох уу?	Төсөл, арга хэмжээний зөвлөх үйлчилгээ, хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж байна.
51	Тендерийн 1-р шатны нээлтийн уулзалтан (2024 оны 3-р сарын 18-ны 11:10 минут) дээр асуулт хариултын үед 1-р шатны бус оролцогч Түншлэлт төлөөлөх эрхгүй оролцож болно гэж дурьдсан. Энэ мэдэгдэл зөв үү?	Болохгүй. Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.
52	Тендерийн 2-р шатны урилга мэйлээр ирсэн билээ. 2-р шатны зарлал руу ороход "Техникийн тодорхойлолт"-ийг хавсаргасан байв. Гэвч тус хавсралт 1-р шатанд ирсэн материалтай яг адилхан байсан. Гэвч удалгүй бидэнд англи Тендерийн баримт бичиг, Өгөгдлийн Pini Gruppe AG Thurgauerstrasse 40 8050 Zürich Schweiz +41 43 205 12 12 zurich@pini.group CHE-102.270.551 MWST CHE-496.284.125 5 6 хэл дээрх орчуулга хүргэгдсэн ба энэ англи хэлдээрх орчуулганд агуулгын нэмэлт өөрчлөлт орсон байв. Аль хэлийг голлон барих вэ?	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх теэдер шалгаруулалтын "ТЭЗҮ", "Тодруулга" хэсэгт байгаа техникийн тодорхойлолтыг баримтална.
53	Тендерийн баримт бичгийг 37-р заалтанд урьдчилгаа төлбөрийг олгохгүй гэж заажээ. Олон улсын туршлагаар төслийг эхлүүлэхэд шаардлагатай зардал үүсдэг. Энэ талаар тодруулга өгнө үү.	Тендерийн баримт бичгийн ТШЗ. 37.1 дагуу Урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.

54	Тендерт Зөвлөх үйлчилгээний төслийн төсөвт өртөгийг дурьджээ. Энэ төсөвт өртөгт татвар хураамжийн талаар дурьдаагүй байна. Татвар хураамжийг үнийн санал дээр хэрхэн тооцох талаар тодруулга өгнө үү. Татварын хөнгөлөлт байх уу?	Батлагдсан төсөвт өртөгт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүхий л зардлыг тооцож оруулна.
55	Тендерийн баримт бичигт тендер худалдаж авах тухай заалт байна. Тендер худалдаж авснаар оролцох эрх үүсэх талаар заажээ. Энэ заалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	Хоёрдугаар үе шатанд тендерийн материал ирүүлэх оролцогч үйлчилгээний хураамж төлөх шаардлагагүй.
56	Тендерийн баримт бичигт зааснаар ТМЗ-ийн ажлын хөлсийг гэрээ байгуулах хэлэлцээрийн явцад тохируулна гэж заажээ. Тохируулгын шаардлагыг дэлгэрүүлж өгнө үү.	Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно..
57	Тус тендерийн 1-р үе шатанд тэнцсэн 20 компаниуд нь түншлэл эсвэл туслан гүйцэтгэгчийн хэлбэрээр хамтран нэгдэж тендерийн 2-р үе шатанд оролцож болох эсэхийг тодруулж өгнө үү.	Болно.